



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: YAГ-CAГ-2018/03-CA



Дүгнэлт: Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаа нь тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгч байгаа боловч түүнд ашиглаж байгаа бие даасан программ хангамжуудын уялдаагүй байдал нь үйл ажиллагааны үр дүнг бууруулж байна.

АГУУЛГА

Тайланг хянасан:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор

А.Цээням

Аудитор

**Б.Цэрэнчимэд
Ж.Өсөхбаяр**

2018 оны 10 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

*Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-
64000
Монгол Улс*

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	2
Аудитын зорилт.....	2
Аудитын хамарсан хүрээ.....	2
Аудитын арга зүй.....	2
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт.....	2
Товчилсон үгийн тайлбар.....	3
Бүлэг нэг • Аймгийн төвийн сум болон сумдын санхүүгийн албаны бүтэц зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.....	4
Аудитын дүн.....	4
Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 36.37 дугаар зүйлд тодорхойлсон боловч аймгийн төвийн суманд ажиллаж байгаа төрийн сангийн нэгжийн зохион байгуулалтыг тодорхой зааж өгөөгүй байна.....	4
Төрийн сангийн тогтолцоо бодлого, чиг үүрэгтэйгээ нийцэж байгаа ч цаашид эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлагатай байна.....	5
Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт нь төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүрэгт нийцэж, төрийн сангийн чиг үүрэг бусад газар хэлтсийн чиг үүрэгтэй давхцаагүй байна.....	6
Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах ажлын төлөвлөгөө гарган жил бүр биелэлтийг тооцож байгаа боловч Сангийн яам төрийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг зохих түвшинд үнэлж дүгнэж чадаагүй байна.....	7
Бүлэг хоёр. Төрийн сан төлбөр тооцоог гүйцэтгэхдээ төрийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлээгүй, ЗГСУМС-ээс хэрэглэгч шаардлагатай мэдээллээ бүрэн хөрвүүлэн авч чадахгүй байна.....	8
Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч төсөвт зохицуулалт хийхдээ Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.....	8
Аймгийн Төрийн сан төсвийн гүйцэтгэл болон өр авлагын мэдээний нэгтгэлийг сум, байгууллага, салбарын дүнгээр, хөтөлбөрөөр харж чадахгүй байгаа нь ЗГСУМС нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.....	15
Төрийн сангийн зайны хяналтыг өдөр тутамдаа ЗГСУМС-д хэрэгжүүлсэн ч төлөвлөгөөт дотоод хяналтыг бүрэн, үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.....	17
Саналд өгсөн тайлбар:.....	20
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	21
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	23
СТСХ-ЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ.....	25
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ.....	26
ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	28
ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ.....	31
ХАВСРАЛТ СУДАЛГАА.....	33

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	<p>Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг Төсвийн байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
Аудитын зорилт	<p>Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх • Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх
Аудитын хамарсан хүрээ	<p>Аудитыг Төрийн сангийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэсэн бөгөөд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс болон 13 сумын санхүүгийн албыг хамруулан түүврийн аргаар шалгав.</p>
Аудитын арга зүй	<p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга, лавлагаа болон судалгаа авч, тайлан баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийн аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	<p>Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:</p> <p><u>Хуулиуд:</u></p> <ul style="list-style-type: none"> •Төрийн аудитын тухай хууль •Төсвийн тухай хууль •Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хууль •Төсвийн тогтвортой байдлын тухай хууль •Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; •Шилэн дансны тухай хууль •Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; •Өрийн удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд <p><u>Засгийн газрын тогтоол:</u></p> <ul style="list-style-type: none"> •Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай 2013 оны 3 дугаар •Санхүүгийн алба байгуулах тухай 2014 оны 326 дугаар тогтоол •Төрийн сангийн үйл ажиллагааны журам 2015 оны 24 дүгээр тогтоол

Сангийн сайдын тушаал:

- “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” 2012 оны 276
- “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам” -2012 оны 194
- “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-2013 оны 73
- “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банкинд нээх, хаах журам”-2013 оны 24/А-9
- “Төрийн сангийн нэгдсэн дансны чөлөөт эх үүсвэрийг удирдах журам”-2014 оны 45
- “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-2014 оны 65
- “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-2014 оны 95, 2015 оны 129-р нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн төлөвлөлтийн журам-2014 оны
- “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-2015 оны 90
- “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-2016 оны 415
- “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-2017 оны 216 болон холбогдох хууль, журмуудыг ашиглана.

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
ОНӨ	Орон нутгийн өмч
ОНО	Орон нутгийн орлого
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨББ	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАГ	Төрийн аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлсэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТС	Төрийн сан
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХО	Хөрөнгө оруулалт
ЭШХО	Эрх шилжсэн хөрөнгө оруулалт

АУДИТЫН ДҮН

Бүлэг нэг • Аймгийн төвийн сум болон сумдын санхүүгийн албаны бүтэц зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 36.37 дугаар зүйлд тодорхойлсон боловч аймгийн төвийн суманд ажиллаж байгаа төрийн сангийн нэгжийн зохион байгуулалтыг тодорхой зааж өгөөгүй байна.

1.1. Төрийн сангийн тогтолцоог төв төрийн сан, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан гэсэн шатлалтай байхаар Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1¹-т, хуулийн 37 дугаар зүйлд “Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг”, хуулийн 38 дугаар зүйлд Төв төрийн сангийн чиг үүргийг хуульчилж өгсөн байна.

Аудитаар төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжихгүй хууль тогтоомж байгаа эсэх талаар “Төрийн сангийн тогтолцооны талаар үнэлгээ өгөх хуудас”-р /Цаашид “үнэлгээ өгөх хуудас” гэх/ санал асуулгыг төрийн сангийн 39 ажилтнаас авахад бүгд байхгүй /*Хавсралт А.1-1-1*/ гэж хариулсан боловч санхүүгийн аудитаар гарч засагдахгүй байгаа зарим нэг зөрчил байна.

Тухайлбал: Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1²-д заасан төсвийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батласан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.4.15³-д төсвийн мэргэжилтэн хэрэгжүүлж төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн тайланг улирал тутамд Сангийн яаманд хүргүүлэхээр заасан байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2⁴ дахь заалтаар аймаг, сумын төрийн сан нь тухайн шатны ЗДТГ-ын дэргэд байхаар хуульчилж өгсний дагуу Засгийн газрын 2002 оны 101 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтцэд Төрийн сангийн хэлтсийг бий болгон аймгийн Төрийн санд ерөнхий нягтлан бодогч болон тухайн төсөвтэй харилцагч 20 хүртэл төсөвт байгууллага тутамд нэг нягтлан бодогч байхаар тогтоосон байна. Засгийн газрын 2016 оны “Аймгийн ЗДТГ-ын бүтцийг батлах” тухай 09 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн баталсны дагуу СТСХ нь 9 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

¹ Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1¹-т” Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ.

² Төрийн сан сан нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах түүнд хяналт тавих

³ ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төсвийн орлогын давалт, тасралт, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны талаарх дэлгэрэнгүй тайланг улирал тутам гаргаж дараа сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлэх.

⁴ Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2⁴-т “...аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна”

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3⁵-т сумдад санхүүгийн нэгдсэн алба байгуулж болно гэж заасны дагуу Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор сумдад санхүүгийн алба байгуулах шийдвэр гарсан байна.

Үүний дагуу Баянхонгор сумаас бусад сумын ЗДТГ-ын дэргэд албаны дарга, мэргэжилтэн, 2 нягтлан бодогчтой Санхүүгийн албыг 2015.01.01-ний өдрөөс байгуулан ажиллаж байна.

Харин Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор аймгийн төвийн Баянхонгор сумын Санхүүгийн албыг 3 орон тоотойгоор байгуулагдсан. Харин дээрх тушаалаар батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 2.2⁶-т заасны дагуу зохион байгуулалт хийгээгүй байна.

Төрийн сангийн тогтолцоо бодлого, чиг үүрэгтэйгээ нийцэж байгаа ч цаашид эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлагатай байна.

1.3. Аудитаар төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж буй эрх зүйн актуудад шинэчлэх сайжруулах шаардлагатай асуудал байгаа эсэх талаар төрийн сангийн 39 ажилтнаас авсан санал асуулгаар 95 хувь нь байхгүй гэсэн бол сумдын төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч 83 хүнээс “нягтлан бодогч нар санхүүгийн албанд харьяалагдан төвлөрч байх нь зөв үү, үгүй юу, үгүй бол шалтгааныг тайлбарлаж бичнэ үү” гэсэн асуултаар санал асуулга авахад 22 хүн буюу 26.5 хувь нь үгүй гэсэн хариулт өгсөн.

Гэвч судалгаанд оролцогчид дараах санал, хүндрэлийг тавьж байсан.

Тухайлбал: Төсөвт байгууллагад ажиллаж байсан 3 нягтлан бодогчийн орон тоог 2 болгож сумын ЗДТГ-т харьяалагдсанаас нягтлан бодогч нарын ажлын ачаалал нэмэгдсэн ч улирлын үр дүнгийн урамшуулал авахгүй болсон, хариуцаж байгаа байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцохгүй болсноор байгууллага дээрх өдөр тутмын нягтлан бодох бүртгэлийн ажил хоцрогддог, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналт суларсан, мөн санхүүгийн албаны дарга нягтлан бодогч нар нэг дор байрлаж байгаагаас бие биэндээ тавих шаардлага, хяналт суларсан зэрэг саналуудыг өгсөн.

Дээрх байдлаас үзэхэд сумдын санхүүгийн албаны ажил үүргийн хуваарилалт, үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

⁵ Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3⁵-т “Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно”

⁶ Хэрэв суманд дээр дурдсанаас олон тооны төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол ажлын ачааллыг харгалзан 3-5 төсвийн байгууллагын дунд 1 нягтлан бодогчтой байхаар орон тооны нормативыг тогтоох бөгөөд хариуцаж байгаа байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж, тэдгээрт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.4. Аймгийн ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогчид ОНХС болон бусад төсөл хөтөлбөрийн зарлагын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурж бүртгэл тайлагналыг хариуцах үүргийг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтнуудын ажил, чиг үүргийн жишиг заавар”-ын 1.2.4⁷- дах заалтаар олгосон байхад харин дээрх тушаалын 2.3.3-т сумдын нягтлан бодогчийн ажлын чиг үүрэгт оруулж өгснийг баримталж ажиллаагүй байна.

Тухайлбал: “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1⁸ дэх заалтыг үндэслэн аймгийн Засаг дарга 2018.01.10-ны өдрийн А/31 тоот захирамжаар, сумдын ОНХС, СХС-ийн 2 дугаар гарын үсгийг сумын Санхүүгийн албаны дарга зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргасан нь Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан жишиг зааврын 2.3.3⁹-т нягтлан бодогч зурахаар тусгасан байгаатай зөрчилдөж байна .

Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт нь төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүрэгт нийцэж, төрийн сангийн чиг үүрэг бусад газар хэлтсийн чиг үүрэгтэй давхцаагүй байна.

1.5. Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын дагуу 2017 онд аймгийн СТСХ, сумдын Санхүүгийн албад нь ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталгаажуулсан байна.

Дээрх тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Сумын санхүүгийн албаны ажил үүргийн жишиг зааврын 2.2.4-т сумын статистик мэдээллийн нэгтгэлийг төсөв, төрийн сангийн мэргэжилтэн хийхээр заасан байхад судалгаагаар 10 сумын Санхүүгийн албаны дарга нар хариуцан хийж, зохих нэмэгдлийг авч, ажлыг хавсран гүйцэтгэж байгаа тул цаашид зааврыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг СТСХ-ийн даргад хүргүүлэв.

Аудитаар хэрэгжүүлж буй чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байгаа эсэх талаар төрийн сангийн ажилтнуудаас санал асуулга авахад 82 хувь нь нийцэж байна гэж хариулсан байна.

1.6. Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс нь аймгийн төсвийн төлөвлөлт бүрдүүлэлт, хуваарилалт, төрийн сангийн зарлага санхүүжилтийг гүйцэтгэх төсөв санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах, нийгмийн даатгал, хөрөнгө оруулалт зээлийн бодлого

⁷ “аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн зарлагын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурж, төсвийн хөрөнгө оруулалтын журмын дагуу ХО-ын ажлын жагсаалт, хяналтын хүснэгтийг үндэслэн бүртгэл, тайлагналтыг хариуцах” /ОНХС, ОНХО, эрх шилжсэн хөрөнгө оруулалт, техник хяналт, мал хамгаалах сан гм/

⁸ Төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд хяналт тавих, зарлагын гүйлгээ хийх эрхийг хоёр гарын үсэгтэйгээр баталгаажуулна. 1 дүгээр гарын үсгийг хууль болон төсвийн ерөнхийлөн захирагчийн тушаалаар эрх олгосон албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн хуульд заасны дагуу төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогч нар зурна. Шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрээр Төрийн өмчийн хорооны гуравдагч этгээдийн гарын үсгийн баталгаа байж болно.


⁹ Засаг даргын нөөц хөрөнгө, СХС, ОНХС... –ийн өдөр тутмын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурах...

төлөвлөлт, зохицуулалт, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, засаг даргын дэргэдэх агентлагуудын төсөв санхүүгийн орлого, зарлагын үйл ажиллагаанд байнга хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба бусад газар, хэлтсийн чиг үүрэгтэй давхцаагүй байна.

Аудитаар төрийн сангийн хэрэгжүүлж буй чиг үүрэг бусад газар, хэлтсийн ажлын чиг үүрэгтэй давхардаж байгаа эсэх талаар төрийн сангийн ажилтнуудаас санал асуулга авахад 97 хувь нь давхцаагүй гэж хариулсан байна.

Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах ажлын төлөвлөгөө гарган жил бүр биелэлтийг тооцож байгаа боловч Сангийн яам төрийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг зохих түвшинд үнэлж дүгнэж чадаагүй байна.

1.7. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, эдийн засгийн оновчтой бодлого, зохицуулалтаар хангах зорилт дэвшүүлэн ажилласан байна.




Дээрх зорилтыг хангахын тулд нийт 6 зорилтын хүрээнд 49 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж 96.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь 2017 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг Сангийн сайдын 2015 оны 215 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн СТСХ-ийн ажлын үр дүнг үнэлж урамшуулах тухай” журмын дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна. Дээрх журмын 3.1.1-т Төрийн сангийн чиг үүргийн хэрэгжилт,

үйл ажиллагааны үр дүнг 15 үзүүлэлтээр, 3.1.2-т Төсвийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааны үр дүнг 5 үзүүлэлтээр, 3.1.3-т Нягтлан бодох бүртгэл, бодлогын үйл ажиллагааны үр дүнг 4 үзүүлэлтээр дүгнэх, үзүүлэлт тус бүрийг 0-10 баллын үнэлгээний системээр үнэлэх ба нийт үнэлгээний дундаж оноогоор нэгдсэн дүн гаргах ажлыг Төрийн сангийн асуудал хариуцсан нэгжид даалгасан байхад одоогоор хэрхэн үнэлэгдсэн талаар албан ёсоор бичгээр ирүүлээгүй байна.

Төрийн сангийн тогтолцооны талаар үнэлгээ өгөх хуудсаар санал авахад санал асуулгад оролцогчдын 46 хувь буюу 18 хүн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах төлөвлөгөөний биелэлтийг үнэлээгүй гэж хариулсан байна.



Бүлэг хоёр. Төрийн сан төлбөр тооцоог гүйцэтгэхдээ төрийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлээгүй, ЗГСУМС-ээс хэрэглэгч шаардлагатай мэдээллээ бүрэн хөрвүүлэн авч чадахгүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч төсөвт зохицуулалт хийхдээ Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1. Баянхонгор аймгийн хэмжээнд төрийн сангийн 21 нэгжээр дамжуулан улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын 137001.4 сая төгрөгийн 73434 гүйлгээг 2017 онд 1011 бүртгэлийн дансаар төлбөр тооцоо хариуцсан 21

мэргэжилтэн ЗГСУМС-д хийж гүйцэтгэснээс сумдын төрийн сангаар дамжуулан хийсэн гүйлгээ нийт гүйлгээний 70.8 хувийг эзэлж байна. /Хавсралт Б.1-1-3/

Дээрх гүйлгээнээс Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын /Цаашид “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” гэх/ 7.11¹⁰-дэх заалтын дагуу орлого бууруулсан 4286 гүйлгээ хийгджээ. Харин төлбөр тооцоо хариуцсан 9 мэргэжилтэн 12 алдаатай гүйлгээг ЗГСУМС-д шивснийг банк хооронд баталгаажин гарахаас өмнө хяналтаар залруулж ажилласан байна.

№	Төрийн сан	2017 оны нийт гүйлгээ		Сарын дундаж гүйлгээний тоо	Өдрийн дундаж гүйлгээний тоо	Алдаатай гүйлгээний тоо
		Тоо	Хувь			
1	Аймгийн төвийн төрийн сан	21456	29.2%	1788	81	1
2	Аймгийн төвийн сумын төрийн сан	8931	12.2%	744	34	2
3	Сумдын Төрийн сан-19	43047	58.6%	188	9	9
НИЙТ		73434	100%	6120	124	12

Баянхонгор аймгийн 13 сум болон аймгийн төрийн санг аудитад хамруулж, 219 төсөвт байгууллагын 366 бүртгэлийн дансаар хийгдсэн 32511 гүйлгээг түүвэрлэн төрийн сангийн төлбөр тооцоог хүчин төгөлдөр анхан шатны баримтаар гүйцэтгэж буй эсэхийг шалгаснаас төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүд “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалтыг зөрчиж төлбөрийн хүсэлтэд 1 ба 2-р гарын үсгийн аль нэг дутуу зурагдсан, төсвийн захирагч, нягтлан бодогч нар нь төрийн санд ирүүлсэн гарын үсгийн баталгааны дагуу гарын үсэг зураагүй, засвартай болон дагалдах нотлох баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн, нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээшхи худалдан авалтын холбогдох нөөц сан үүсгэж, амлалтын бүртгэл хөтлөөгүй зэргээр 748 гүйлгээ хийсэн зөрчил илэрлээ. /Хавсралт Б.1-1-1/ Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.5¹¹, 7.6 дахь заалтыг зөрчин 85 гүйлгээ хийгдсэнээс Бөмбөгөр сумын төрийн сан гарын үсгийн бүрдэл дутуу байхад 14 гүйлгээ хийсэн, Бууцагаан сумын төрийн сан гарын үсгийн бүрдэл дутуу болон, засвартай төлбөрийн хүсэлтээр 4 гүйлгээ, Баянхонгор сум 41, Жинст сум 1 гүйлгээ хийсэн, аймгийн ОНХСангаас Баянцагаан сумын СХС-д илүү шилжүүлсэн санхүүжилтийг буцааж шилжүүлэхдээ төлбөрийн хүсэлт бичээгүй гүйлгээ хийсэн байна.

¹⁰ 7.11. Тухайн байгууллагын данснаас дараах тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө:

¹¹ 7.5. Тухайн байгууллага бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн хүсэлтийг... ..ТС-д хүргүүлнэ. Төлбөрийн хүсэлтийн... ..бусад мэдээлэлд засвар хийхийг хориглоно.

-“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.8 дахь заалтыг зөрчин 32 гүйлгээ хийгдсэнээс Баянбулаг сумын төрийн санд ОНХС-ийн хөрөнгөөр батлагдсан төсөл арга хэмжээний санхүүжилтийг батлагдсан төсвөөс 12,2 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн, Баян-Овоо сумын төрийн сан ОНХСангийн гүйлгээний анхан шатны баримт дутуу байхад 20 гүйлгээ хийсэн, Баянцагаан сум ОНХСангаас 1 байгууллагад гэрээнд заасан нөхцөлөөс илүү хэмжээгээр урьдчилгаа санхүүжилтийг олгосон, Эрдэнэцогт сум ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо Цэвэр хот ОНӨ ХХК-д шилжүүлэх санхүүжилтийн 2 гүйлгээг Шунхлай ХХК, Баянхонгор сумын Хог тээврийн орлогын дансанд шилжүүлсэн, анхан шатны баримт дутуу байхад Эрдэнэцогт сум 6, Баянхонгор сум 2 гүйлгээг шилжүүлсэн байна.

-“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.11-д заасны дагуу 656 орлого бууруулах гүйлгээ хийгдсэнээс 526 гүйлгээ нь журмын 7.12 дахь заалтыг зөрчиж төлбөрийн хүсэлтийг дахин бичүүлээгүй мөн орлогын хуульыг хавсаргаагүй гүйлгээ хийсэн байна.

-“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.14 дахь заалтыг зөрчиж Баян-Овоо сумын төрийн сан 90004 данснаас гарах гүйлгээг 90005 данснаас хийсэн, Галуут сумын төрийн сан Татварын орлого төвлөрүүлэх 37,5 мянган төгрөгийн гүйлгээг буруу шивж залруулахдаа маягт ТТ-7 бичиж баталгаажуулаагүйгээр нийт 2 гүйлгээ хийсэн байна.

-“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.2, 8.10 дахь заалтыг зөрчиж Баянхонгор сумын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн төлбөрийн хүсэлтийг 3 хоногоос хэтрүүлж 1 гүйлгээ хийсэн.

- Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.4 дэх заалтыг зөрчсөн 7 гүйлгээ хийсэн байна. Үүнд: Баян-Овоо сумын төрийн сан сургуулийн дээврийн засварын ажлын гүйцэтгэлийг актаар хүлээн аваагүй байхад санхүүжилтийг 301,0 мянган төгрөгөөр илүү олгосон байсанд СТА-р акт тогтоосон, аймгийн СТСХэлтсийн төрийн сангаас Засаг даргын захирамж гарахаас 2 хоногийн өмнө спортын шагнал урамшуулалд **32,9** сая төгрөг, Захирамж гараагүй байхад **123,3** сая төгрөгийн 2 гүйлгээ, гэрээ батлагдаагүй байхад **135,2** сая төгрөг, гэрээний заалт зөрчиж **21,0** сая төгрөгийн санхүүжилт шилжүүлсэн, Жинст сумын төрийн сан эдийн засгийн ангилал, хөтөлбөр зориулалтыг зөрүүлж 1 гүйлгээг тус тус хийсэн байна.

-Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.5 дахь заалтыг зөрчиж 30 гүйлгээ хийсэн байна. Үүнд: ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын санхүүжилтийг олгохдоо Бөмбөгөөр сум 1, Бууцагаан сум 1, Галуут сум 2 гүйлгээг Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан журмын дагуу гүйцэтгэл бичүүлээгүй байхад олгосон, Эрдэнэцогт сумын төрийн сан төсөл арга хэмжээний зардлаас захиалагчийн хяналтын зардлыг суутгаж тооцоогүй 2 гүйлгээ хийсэн, аймгийн техник хяналт, барьцаа дансанд 24 гүйлгээгээр магадалшгүй ажлын зардал, нормчлолын сангийн зардал, хөрөнгө оруулалтын засварын зардлыг илүү төвлөрүүлсэн байна.

-Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 9.1.4-т “энэхүү журмын 9.2 дахь заалтад хамаарахаас бусад тохиолдолд урсгал санхүүжилтийн данснаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээш үнийн дүнтэй худалдан авалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан ТТ-4 маягтын хамт Төрийн санд хүргүүлж батлагдсан төсвөөс нөөц үүсгэн бүртгүүлнэ” гэж заасан байхад ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээших худалдан авалтын холбогдох ажлын нөөц сан үүсгэж, амлалтын бүртгэл хөтлөөгүй байхад 65 гүйлгээний төлбөр тооцоог шууд гүйцэтгэсэн байна.

Төрийн сангийн төлбөр тооцооны баталгаажуулалтыг үнэн зөв гүйцэтгэж байгаа эсэхийг шалгахад “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.6¹² дахь заалтыг зөрчиж зарим сумдын төрийн сан нотлох баримтын бүрдэл дутуу өөрөөр хэлбэл холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад буюу гэрээ баталгаажихаас өмнө, журмын зохих шаардлагуудыг хангаагүй байхад зарим гүйлгээг зөвшөөрч төрийн сангийн тэмдэг дарж, гарын үсэг зурж, баталгаажуулж зарлага гаргасан байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

¹² “Төрийн сан төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтэн дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан...”


• Баян-Овоо сумын Төрийн сан 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн зарим хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо ажил нь бүрэн дуусаагүй байхад 40-70 хоногийн өмнө буюу 2017.09.20-ны өдөр ажлын санхүүжилтийг сумын төрийн сан нь зөвшөөрч, тэмдэг дарж **48.9 сая төгрөгийн гүйлгээ хийж 100,0 хувь олгосон байна /ажлуудыг хүлээлгэн өгсөн акт 2017.10.29-12.11-нд гарсан/.**

• Аймгийн Төрийн сангаас аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн Баянхонгор сумын 4-р багийн хөгжлийн төвийн 450,6 сая төгрөгийн барилгын ажил гүйцэтгэх гэрээг 2017.08.11 байгуулсан байхад, 2017.08.10-нд 135,2 сая төгрөгийн 30 хувийн санхүүжилтийн урьдчилгааг гүйцэтгэгч Ганмөнхжин ХХК-д олгосон.

Мөн зөвхөн Засаг даргын захирамжийг үндэслэн Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн золголт, уралдаан тэмцээний шагнал, хоол байрны үнэ зэрэг “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчиж зарлагын гүйлгээг хийж байгаа нь төрийн сангийн хяналт зарим талаар хангалтгүй хийгдэж байгааг илэрхийлж байна.

Цаашид төрийн сан төсөл арга хэмжээний шилжүүлгийн гүйлгээг батлахдаа гэрээ батлагдахаас өмнө санхүүжилт олгодог байдлыг зогсоож, ажлын гэрээнд заасан заалтыг бүрэн мөрдөж байгаа эсэх, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаад хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитаар Төрийн сангийн үйл ажиллагааны талаар харилцагч төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч 108 хүнээс санал асуулга авахад дараах хариултыг өгсөн байна.



Баянхонгор аймгийн төрийн сангаар гүйлгээ хийж буй нууцын зэрэглэлтэй байгууллагын бүртгэл хөтөлж тэдгээрийн гүйлгээг хийх ажилтныг томилж нууцын баталгаа гаргуулсан баримт байхгүй байна. Харин төрийн сангийн төлбөр хариуцсан мэргэжилтнүүд нууцын зэрэглэл бүхий 4 байгууллагын зарлагын гүйлгээ

хийхдээ “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.9¹³-д заасны дагуу төлбөрийн хүсэлтийн үндэслэх баримтыг шаардахгүйгээр гүйлгээг хийсэн байна.

Цаашид нууцын зэрэглэл бүхий байгууллагын бүртгэлийг хөтөлж, гүйлгээ хийх ажилтныг томилж нууцын баталгааг гаргуулан хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Түүвэрт хамрагдсан төрийн сангийн нэгжүүдийн тэмдэг, баталгааны тэмдгийн хадгалалт хамгаалалтын байдлыг шалгахад ихэнх сумдын ажилтнууд тэмдгийг ширээ, шүүгээндээ хадгалж байгаа тул цаашид Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”-ын 36¹⁴-т заасны дагуу хадгалалт хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

2.2. Аймгийн Төрийн санд 1011 бүртгэлийн данс ашиглагдаж байгаа ба 2017 онд 24 данс шинээр нээсэн байна. Үүнээс улсын төсвийн байгууллагын 95 данс, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 793 данс, нийгмийн даатгалын багцын 123 данс бүртгэлтэй байна. /Хавсралт Б.1-2-1/

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын дансанд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3197.2 сая төгрөгийн үлдэгдэл байршиж байгаа ба ОНХО-ын дансанд 892.3 сая, ОНХС-ийн дансанд 747.4 сая, сум хөгжүүлэх сангийн дансанд 834.8 сая, техник хяналт, барьцаа дансанд 622.8 сая, замын санд 43.4 сая, 2015, 2016 оны нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлэлт дансанд 56.2 сая төгрөг байгааг байгууллагууд дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан байна.

Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банкинд нээх, хаах журам”-ын дагуу Төрийн болон ХААН банкинд төрийн сангийн болон төсөвт байгууллагын жижиг мөнгөн сан, 0 үлдэгдэлтэй дансыг байршуулан, журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны 5 банкинд төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 49 дансанд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 719.4 сая төгрөгийн үлдэгдэл байршиж байна. Энэ нь орон нутгийн өмчит байгууллагуудын 611.9 сая, төсөл сангийн 75.6 сая, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 31.5 сая, төсөвт байгууллагуудын 0.4 сая

¹³ 7.9. Төрийн нууцад хамаарах, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой зардлын гүйлгээнд энэхүү журмын 7.8 дахь заалт хамаарахгүй

¹⁴ 36. Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг ажлын байранд бөх бат саванд хадгална.

төгрөгийн үлдэгдэл байршиж байгааг байгууллагууд тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. /Хавсралт Б.1-2-2/

Баянхонгор аймгийн төрийн сан болон харьяа байгууллагууд нь хадгаламжийн данс болон үнэт цаас байхгүй байна. /Хавсралт Б.1-2-3, Б.1-2-4/

Баянхонгор аймгийн Төрийн сангийн техник хяналт, барьцаа данс нь 2017.01.01-ний байдлаар 176,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 864,6 сая төгрөгийн орлого орж 418,6 сая төгрөгийг зарцуулан оны эцэст 622,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба энэ нь 2017 онд үүссэн байна. /Хавсралт Б.1-2-4/

№	Гүйлгээний утга	дүн	Тайлбар
1	Баянбулаг, Шаргалжуут ЭМТ-ийн барилгын ХО-ын барьцаа	111.3	Сумдын ЭМТ-ийн барилгын ХО-ын барьцаа
2	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа /16 ААНБ-ын/	365.7	Байгаль нөхөн сэргээлт
3	ЭМС, БШУС-ийн ЭШХО-ын 3 ТАХ	85.9	Бөмбөгөр сумын ЭМТ, аймгийн ЭМТ, Баянговь сумын Соёлын төв
4	Техник хяналтын зардал	19.7	Техник хяналтын орлого
5	ТАХ-ны магадалшгүй ажлын зардал	39.8	Төсөвт тусгагдсан МАЗ
6	ТАХ-ны нормчлолын сангийн зардал	0.4	Нормчлолын сангийн зардал
Нийт дүн		622.8	

Дээрх хүснэгтээс харахад Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа уул уурхай эрхлэгч 16 аж ахуйн нэгж байгууллагаас нийт 365,8 сая төгрөгийг дансанд төвлөрүүлсэн нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 79 тоот тогтоолоор батлагдсан “Нөхөн сэргээлтийн талаар авах арга хэмжээний тухай”, Баянхонгор аймагт зохион байгуулсан “Уул уурхайн зөвлөгөөн”-өөс гаргасан шийдвэрийг үндэслэн гэрээ хийж авсан гэх боловч гэрээ байхгүй, гэрээг Авилгатай тэмцэх газраас шалгахаар авч явсан гэсэн тайлбарыг өгсөн.

Аудитаар төрийн санд байрших барьцаа хөрөнгийн дансанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх засварын ажлын санхүүжилт, хөрөнгө оруулалтын ажлын магадалшгүй ажил, нормчлолын сангийн зардлыг төвлөрүүлсэн, тайлант оны дундуур зориулалт бусаар зарлагын гүйлгээ гаргаж буцаан төвлөрүүлсэн зөрчил илэрлээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

-Тус дансанд 2017.12.26-ны өдөр УТХО-аар хэрэгжих 3 төсөл арга хэмжээний 85.9 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан зөрчил илэрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

-2017 онд хэрэгжүүлсэн 11 төсөл арга хэмжээний 39,9 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардал, 10 төсөл арга хэмжээний 0.4 сая төгрөгийн нормчлолын сангийн зардлыг техник хяналт, барьцааны дансанд төвлөрүүлсэн нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.5-д Хөрөнгө оруулалтын зардлын гүйлгээг гүйцэтгэхдээ дансны хуулгыг үндэслэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний төлбөрийн нөхцөлд заасан барьцаа, техник хяналт болон гүйцэтгэгчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн тул 40.3 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэх зөвлөмж хүргүүлэв.

-Төрийн санд байрших техник хяналт, барьцаа данснаас 2017.07.26-нд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 56.7 сая төгрөгийн автомашины үнийг шилжүүлж, 2017.12.21-нд 54,0 сая, 2017.12.28-нд 2,7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.4¹⁵ дэх заалтыг зөрчсөн тул цаашид барьцаа дансанд байршиж буй эх үүсвэрээс барьцааг олгохоос бусад зориулалтаар зарлагын гүйлгээ гаргахгүй байх, техник хяналт болон барьцаа хөрөнгийн дансыг тус тусад нь данс нээж бүртгэх зөвлөмжийг хүргүүлэв.

Иймд төрийн санд байршиж байгаа барьцаа хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг хамгаалж улсын хэмжээнд мөнгөн хөрөнгийн удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгоор Сангийн яам дээрх эх үүсвэрүүдийг ашиглан орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх саналыг ҮАГ-т хүргүүлж байна.

2.3. Аймгийн Засаг дарга 2016 оны А/623 тоот захирамжаар Замын сан, Хөрөнгө оруулалтын техник хяналтын барьцаа, эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын дансны төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсэг зурж, төсвийг захиран зарцуулах эрхийг ЗДТГ-ын СТСХ-ийн даргад олгосон нь Төсвийн тухай хуулийн 14.4¹⁶, 14.1.17¹⁷ дахь заалтыг зөрчиж төрийн сангийн төлбөр тооцоонд тавих дотоод хяналтыг сулруулж байна.

Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4.1.7¹⁸, 5.2¹⁹-т төсөвт байгууллагууд төсөвт зохицуулалт хийх саналаа аймгийн Засаг даргад хүргүүлэхээр заасны дагуу байгууллагууд журмын 4.2²⁰-д заасны дагуу албан бичиг болон холбогдох материалыг ТЗБ№1 маягтын хамт бүрэн ирүүлээгүй байхад аймгийн Засаг даргын 2017 оны А/873 тоот захирамжаар зохицуулалт хийсэн нь Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4.2 дэх заалтыг зөрчсөн байна.

Тухайлбал: Аймгийн ТЭЗ-ийн харьяаны 100 байгууллагын төсөвт зохицуулалт хийснээс 46 байгууллага журмын дагуу албан тоотоор хүсэлтээ Засаг даргад ирүүлсэн бусад байгууллагуудын хүсэлтийг хүлээн авсан гэх боловч баримтыг архивын нэгж үүсгэн хадгалаагүйгээс нотлох боломжгүй байна.

¹⁵ Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.4-д “...Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана”

¹⁶ “ТЭЗ нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ ТТЗ, эсхүл харьяалах ТШЗ-д шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”,

¹⁷ аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч байна.

¹⁸ “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлыг авсан байх”,

¹⁹ “Төсвийн байгууллага зардлын бүлэг хоорондын зохицуулалтын хүсэлтийг ТЗБ№1 магтаар бэлтгэн, энэ журмын 4-т заасан шаардлагыг хангасан материалын хамт харьяа төрийн санд хүргүүлнэ”

²⁰ 4.2.Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх санал нь дараах агуулгатай байна

Дээрхи журмын 5.3²¹, 5.5²² дахь заалтын хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны А/873 тоот захирамжаар байгууллагуудын төсөвт зохицуулалт хийхдээ боловсролын салбарын 53 байгууллагын 252,8 сая төгрөгийн зардлыг бүлэг хооронд, Эрүүл мэндийн салбарын 11 байгууллагын 28.2 сая төгрөгийн зардлыг зардлын бүлэг хооронд, орон нутгийн төсөвт 3 байгууллагын 116.4 сая, Халамжийн сангийн 302.5 сая төгрөгийн зардлыг зардлын бүлэг хооронд зохицуулсныг ЗГСУМС-д тодотгож оруулсан байна.

Аймгийн төрийн сан нь Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын 4.3 дахь заалтын хүрээнд санхүүжилтийг олгосон байна. Мөн журмын 3.2. дахь заалтын дарааллаар төлбөрийг гүйцэтгэж байна.

Төсвийн байгууллагууд нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг нээлгэх хүсэлтийг НТН№1 маягын дагуу бэлтгэн, холбогдох бичиг баримт, шийдвэр, гэрээ, нэмэлт төсвийг зарцуулах төсвийн захирагчийн баталсан төсөв, сарын хуваарь, нэмэлт санхүүжилтийн орлогын хуулга зэргийг хавсаргаж, төрийн санд албан бичгээр хүргүүлж, зарцуулалтын эрхийг нээлгэж, зарцуулсан байна.

Аймгийн Төрийн сан төсвийн гүйцэтгэл болон өр авлагын мэдээний нэгтгэлийг сум, байгууллага, салбарын дүнгээр, хөтөлбөрөөр харж чадахгүй байгаа нь ЗГСУМС нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

2.4. Төрийн сан нь төсвийн байгууллагуудын бүртгэлийн дансдаар санхүүжилт олгох, гүйлгээ хийх, тайлан авах, батлагдсан төсвийн хүрээнд төсвийн хэрэгжилтийг “Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр гүйцэтгэж байгаа ба системд мөрдөх журам”-ыг Сангийн сайдын 2014 оны 95 тоот тушаалаар баталсан байна.

2017 онд аймгийн Төрийн сангийн нэгжүүдийн ЗГСУМС-д нэвтрэх эрх бүхий ажилтнуудаас дээрх журмын хавсралт маягт-1, маягт-2-ын дагуу 13 хэрэглэгч бүр, 28 хэрэглэгч түр хугацаагаар эрхээ шилжүүлсэн ба системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн бүртгэлийг журмын 2.1²³-д заасны дагуу аймгийн ЗДТГ-ын 2017 оны

²¹ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн захирагчаас ирүүлсэн саналыг судлан үзээд зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд тухайн зардлын бүлгийн батлагдсан төсвийн жилийн дүнгийн 120 хувиас хэтрэхгүй, 10,0 сая төгрөг хүртэлх зохицуулалтыг хийж, ТЗБ №1 маягтаар бүрэн баталгаажуулна”

²² 5.5 Төсвийн байгууллага журмын 5.1-т заасан бусад төсвийн зохицуулалт хийх саналыг Төсвийн ерөнхийлөн захирагчид хандан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ.

²³ 2.1 Төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газар, хэлтэс, аймаг, нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтсүүд харьяа аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн нэгжүүдийг нэгтгэн шинэ оны системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн нэрсийн жагсаалтыг энэхүү журмын 3 дугаар бүлгийн ажил үүргийн ангиллын дагуу жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Төв төрийн санд албан бичгээр ирүүлнэ.

5/1624 тоот албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.

Аудитаар ЗГСУМС-ийн 36 хэрэглэгчээс ЗГСУМС нь хэрэглэхэд ойлгомжтой, таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чадаж байгаа эсэх талаар санал асуулга авахад:

- Өргөн сонголтоор төсөв хянах цэсний тохиргоо муу
- Гүйлгээ хянах явцад төсвийн хяналт хийдэггүй
- Системд өгөгдөл оруулах, тайлан мэдээ боловсруулах, тайлан мэдээ гаргахад сүлжээ саатдаг, программ уншиж гацдаг
- Хуулга, ня-бо журнал уншигддаггүй тул төрийн сангийн сүлжээний хурдыг сайжруулах шаардлагатай гэсэн саналыг бичгээр өглөө. /Хавсралт судалгаа Б.2-1-1, Б.2-1-2/

№	Асуулт, хариу бөглөх хэсэг	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу?			ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чаддаг уу?			ЗГСУМС-д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу?			Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу?		
		Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй
	ДҮН	24	12	-	24	12	-	8	22	6	23	7	6
	Хувь	67%	33%	0%	67%	33%	0%	22%	61%	17%	64%	19%	17%

Мөн системд өдөр тутмын ажил гүйлгээг гүйцэтгэхэд танаас үл шалтгаалах системийн алдаа дутагдал байгаа эсэх талаар санал авахад:

- Сүлжээний хурдаас хамаарч хуулга зарим тохиолдолд гардаггүй
- Сумдад бэлтгэн нийлүүлэгчийн нэрийг засах эрхгүй
- Төсөв хүрэхгүй гүйлгээг шивэхэд хэвийн шивэгдээд гүйлгээ батлахад алдаа заадаг
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээний нэгтгэлийг аймагтаа сум, байгууллага, салбарын дүнгээр үүсгэж харж болдоггүй
- Системээс хөтөлбөр зориулалтаар бүрэн ашиглагдахаар тайлангууд хөрвөж гарахгүй байгаа нь аймагт ашиглах мэдээллүүдийг бүрэн харах боломжгүй байна гэсэн саналуудыг өгсөн байна.

Цаашид доорхи саналуудыг холбогдох байгууллагуудад ҮАГ-р дамжуулан уламжилж байна.

Санал

-Аймгийн ихэнх сумд шилэн кабелийн сүлжээнд холбогдсон байхад төрийн сангийн мэдээлэл нь VSAT-р дамждагаас сүлжээний хурд удаан, гацах доголдох тохиолдол нийтлэг гардагаас төрийн сангийн сүлжээг шилэн кабелийн сүлбээнд холбож хурдыг нэмэгдүүлэх.

-Төсвийн мэргэжилтэн орон нутагт хийсэн тодотголыг төсвийн төлөвлөлтийн Fiscal программд шивж оруулан Сангийн яаманд илгээж, Сангийн яам тус программаас төрийн сангийн Free balance программд оруулж байгаа нь цаг хугацааны хувьд удааширалтай, төсөв зөрүүтэй татагддаг тул Fiscal программд оруулсан төлөвлөгөөг Free balance программд шууд татуулж төсвийн гүйцэтгэлийн мэдээний нэгтгэлийг сум, байгууллага, салбарын дүнгээр, хөтөлбөрөөр үүсгэж хардаг болох.

-Байгууллагуудаас сар бүр авч программд оруулсан өр авлагын мэдээг нэгтгэлээр харах боломжтой болгох, сумын төсвийн нэгдсэн хэлбэлзэлийн тайланг сар, улирлаар гаргадаг байх.

-Төсвийн захирагч, нягтлан бодогч нар нь Төрийн санд ирүүлсэн гарын үсгийн баталгаанаас өөрөөр төлбөрийн хүсэлтэн дээр зурсан зөрчил нийтлэг байгаа тул ЗГСУМС-ийг илүү үр дүнтэй техникийн шийдэл ашиглаж гарын үсгийн баталгааг цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр сайжруулах.

2.5. ЗГСУМС-ийн аюулгүй байдалд учруулдаг болон болзошгүй эрсдэлийг хэрэглэгчдээс санал асуулгаар авахад одоо ашиглагдаж буй компьютерийн хүчин чадал хангалтгүй, хуучирсан, гэнэтийн аюул осол, эрчим хүчний доголдлоос шалтгаалан тоног төхөөрөмж шатах, гэмтэх мөн сүлжээний хурд муу байгаагаас программын алдаа гарч гүйлгээ саатах эрсдэлтэй гэсэн саналуудыг өгч байгаа нь мэдээллийн технологийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй байна.

Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн Fiscal, төрийн сангийн төлбөр тооцооны Free balance, санхүүгийн тайлангийн нэгтгэлийн Э-тайланг санхүүгийн үйл ажиллагааг илүү боловсронгуй түргэн шуурхай явуулах зорилгоор найдвартай үйл ажиллагааг хангасан вэб дээр суурилсан нэгдсэн цогц программ хангамжийг нэвтрүүлэхийг ҮАГ-р дамжуулан Сангийн яаманд уламжлах саналыг хүргүүлж байна.

Цаашид төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн Acolous программ, хангамжид өөрчлөлт хийх бүр төлбөр төлж байгаа тул зардлыг хэмнэж дээрх нэгдсэн программ хангамжтай уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

Төрийн сангийн зайны хяналтыг өдөр тутамдаа ЗГСУМС-д хэрэгжүүлсэн ч төлөвлөгөөт дотоод хяналтыг бүрэн, үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

2.6. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5.1²⁴-д заасны дагуу сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг журамд заасан аргачлалын дагуу эрсдэлийн үнэлгээ хийж Сангийн яаманд хүргүүлсэн байна. Эрсдэлийн үнэлгээгээр Баянговь сумын төрийн сангийн нэгж дунд гэсэн үзүүлэлттэй, бусад төрийн сангийн нэгжүүд бага гэсэн үзүүлэлттэй үнэлэгдсэн байна.

²⁴ Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан жил бүрийн эхэнд төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг журамд заасан аргачлалын дагуу үнэлж, удирдлагад танилцуулна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь дотоод хяналтын чиглэлээр 7 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээр 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулж батлуулсан байна.

№	Төрийн сангийн нэгжийн нэр	Төлөвлөгөө						Хяналт хэрэгжүүлсэн эсэх
		1-р улирал		2- улирал		3-р улирал		
		2 сар	3 сар	5 сар	6 сар	9 сар		
1	Баянговь				+		-	
2	Гурванбулаг	+					Тийм	
3	Өлзийт		+				-	
4	Галуут	+					Тийм	
5	Баянцагаан				+		-	
6	Баянхонгор					+	-	
7	Шинэжинст				+		-	
8	Заг	+					Тийм	
9	Баянбулаг			+			-	
10	Эрдэнэцогт		+				Тийм	
11	Баян-Овоо		+				Тийм	
12	Хүрээмарал			+			-	
13	Жаргалант	+					Тийм	
Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь							46.10%	

Сангийн сайдын 2014 оны 65 тоот тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 4.3-т заасны дагуу аймгийн Засаг даргын 2017 оны А/94 тоот захирамжаар 5 удаагийн хяналт шалгалтаар 13 сумын төрийн сангийн үйл

ажиллагаанд дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг батлуулж 6 суманд хяналт шалгалт хийжээ.

СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь Галуут, Баян-Овоо, Гурванбулаг, Жаргалант, Заг, Эрдэнэцогт сумдын төрийн сангийн 2017 оны мемориалын баримт, төсөвт байгууллагуудын гарын үсгийн баталгааны бүрдэл ЗГСУМС-д хийгдсэн гүйлгээ, ЗГСУМС-д оролцож буй хэрэглэгчийн шилжилт хөдөлгөөний бүртгэл, эрх олгосон нэмэлт санхүүжилт, олгосон урсгал санхүүжилт, төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэсэн байдал, төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авалт, санхүүгийн албаны ажилтнуудын ажил үүргийн оновчтой хуваарилалт зэрэгт хяналтыг хэрэгжүүлж, гарсан зөрчилд давхардсан тоогоор 154 зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон ажилласан байна. Харин төлөвлөснөөс 7 сумын төрийн сангийн ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүйгээс ажлын гүйцэтгэл 46.1 хувьтай байгаа ч төрийн сангийн мэргэжилтнүүдийг эрсдэлээс хамгаалах, нягтлан бодогч нарын ажилд байнгын хяналт хийх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/127 дугаар захирамжаар “Төсөвт байгууллагад төлбөр тооцооны гүйлгээ хийх эрх олгох журам” батлуулж, төрийн сангийн зайны хяналтыг өдөр тутам хэрэгжүүлсэн, гүйлгээ хүлээх авах, хянах, шивэх талаар сургалтын гарын авлагыг бэлтгэн хүргүүлсэн, мөн утсаар болон цахим хаягаар заавар зөвлөгөө өгч ажилласны үр дүнд 2017 онд алдаатай гүйлгээний тоо өмнөх оноос 98-аар буюу 99.9 хувиар буурч 12 алдаатай гүйлгээ хийгдсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу “Хишиг өдөр” аян, “Санхүүгийн ажилтнуудыг

чадавхижуулах” бүсчилсэн сургалтыг Галуут Жинст суманд зохион байгуулж 136 хүн хамрагдсан байна. Сургалтыг цахим худалдан авалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмжийн биелэлтэд анхаарч ажиллах чиглэлээр өгсөн байна. Мөн аймгийн төрийн санд 15 нягтлан бодогч “Хишиг өдөр аян”-ы хүрээнд ажиллаж, бусад төсвийн байгууллагуудын төлбөрийн хүсэлт, бэлэн мөнгөний хүсэлт, анхан шатны баримтыг тулган хянаж, алдаатай болон баримтын бүрдэл дутуу гүйлгээг буцаах, төрийн сангийн үйл ажиллагаанд өдөр тутамд хэрэглэгддэг хууль, заавар журамтай танилцаж, туршлага судлах, суралцах, бусдад өөрийн туршлагаа хэлж өгсөн нь алдаа зөрчлийг бууруулах давтан гаргахгүй байхад чухал нөлөө үзүүлсэн үр дүнтэй ажил болсон байна.

СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.5.5²⁵-д заасан ажлын чиг үүргийн дагуу хэлтсийн системд өдөр тутам бүртгэсэн гүйлгээг хянан баталгаажуулдагаас сумдад очиж дотоод хяналт хийх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтнээр “Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх журам”-ын 6.1.5²⁶, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухайн хууль”-ийн 8.1²⁷-д заасны дагуу хяналт тавих төрийн сангийн нэгжүүдэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргуулаагүй байгаа тул цаашид нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй тухай мэдэгдэл гаргуулж байх шаардлагатай байна.

2.7. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн 2017 онд 6 сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт хийж 154 заалт бүхий зөвлөмж өгснөөс 3 сум бүрэн, 3 сум дутуу хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 80.7%-тай байна. Үүнд:

№	Сумын нэр	Хяналт хийсэн хугацаа	Өгсөн зөвлөмжийн тоо	Биелэлтийн хувь
1	Галуут	2017.02.11	28	75.0
2	Баян-Овоо	2017.03.14	13	84.6
3	Гурванбулаг	2017.02.08	25	100.0
4	Жаргалант	2017.02.10	32	100.0

²⁵ төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь хэлстийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний системд бүртгэсэн гүйлгээг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн баталгаажуулах

²⁶ Хяналт тавих нэгжүүдэд ашиг сонирхлын зөрчилгүй байх

²⁷ Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

5	Заг	2017.02.09	28	25.0
6	Эрдэнэцогт	2017.02.15	28	100.0
Нийт			154	80.7

Төрийн сангийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтаар гарсан зөрчлүүд аудитаар давтагдан гарч байгаа тул цаашид жил бүр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтын тоог нэмэгдүүлж төрийн сангийн нэгжүүдийн 70-с дээш хувийг хамруулж байх шаардлагатай байна.

Аудитаар нийт 544.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, орон нутгийн орлогын дансанд 40.3 сая төгрөгийг төвлөрүүлж, цаашид алдаа зөрчлийг арилгах 503.9 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлэв.

Саналд өгсөн тайлбар:

Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн 2 саналаас 2017 оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 40.5 сая төгрөгийг тооцоо нийлж дуусаагүй учир үлдэгдэлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжгүй гэснийг судалж саналын дагуу хүлээн авлаа.

Харин Сангийн сайдын 2017 оны 13 дугаар тушаалаар амлалтын бүртгэл хөтлөгдөхгүй болсон тул тухайн гарсан зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй байна гэсэн санал нь дээрх тушаалд Сангийн сайдын 2003 оны 315 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагад бүртгэгдэх амлалтын бүртгэлийн түр журам”-ыг хүчингүй болгосон, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлд амлалтын бүртгэл хөтлөхөөр журамласан байгаа тул хүлээн авах боломжгүй байна.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн нэгдсэн тайланд тусгуулан холбогдох газарт уламжлах саналыг 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/121 тоот албан бичгээр Үндэсний Аудитын газарт хүргүүлсэн болно.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 36.37 дугаар зүйлд тодорхойлсон боловч аймгийн төвийн суманд ажиллаж байгаа төрийн сангийн нэгжийн зохион байгуулалтыг тодорхой зааж өгөөгүй байна.

2. Төсвийн мэргэжилтэн Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 -д заасны дагуу төсвийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж тайланг улирал тутамд гаргаж Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

3. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт нь төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүрэгт нийцэж байгаа ч Санхүүгийн албаны дарга нар төрийн сангийн мэргэжилтний чиг үүрэгт хамаарах сумын статистик мэдээний нэгтгэлийн ажлыг хийж гүйцэтгэж байна.

4. Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах ажлын төлөвлөгөө гарган жил бүр биелэлтийг тооцож байгаа боловч Сангийн яам төрийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг зохих түвшинд үнэлж дүгнээгүй байна.

5. Төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхдээ Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс 748 гүйлгээ журам зөрчиж хийгдсэн, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаад хяналт тавиагүй, техник хяналт, барьцаа дансанд зориулалт бусаар засвар, магадалшгүй ажлын зардал 126.2 сая төгрөгийг оны эцэст байршуулсан.

6. Аймгийн Засаг даргын захирамжаар Замын сан, Хөрөнгө оруулалтын техник хяналтын барьцаа, эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын дансны төсвийг захиран зарцуулах эрхийг СТСХ-ийн даргад олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг зөрчиж төрийн сангаас төлбөр тооцоонд тавих дотоод хяналтыг сулруулж байна.

7. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч төсөвт зохицуулалт хийхдээ Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дэх заалтыг зөрчсөн байна.

8. Аймгийн Төрийн сан төсвийн гүйцэтгэл болон өр авлагын мэдээний нэгтгэлийг сум, байгууллага, салбарын дүнгээр, хөтөлбөрөөр харж чадахгүй байгаа нь ЗГСУМС нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

9. Төрийн сангийн зайны хяналтыг өдөр тутамдаа ЗГСУМС-д хэрэгжүүлсэн ч төлөвлөгөөт дотоод хяналтыг бүрэн, үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2018.10.31

Баянхонгор хот

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорхи албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Нэг. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа

1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1.7 дэх хэсэгт заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчаас бусад албан тушаалтан буюу СТСХ-ийн даргад төсөв зарцуулах эрхээ шилжүүлэхгүй байх.

2. Барилга байгууламж болон нөхөн сэргээлтийн барьцаа дансанд байршуулсан хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж буцаан байршуулж байгаа зөрчлийг цаашид гаргахгүй байх.

3. Төсөвт байгууллагуудын төсөвт зохицуулалт хийхдээ Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах.

**Хоёр. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа,
сумдын Санхүүгийн албаны дарга нарт**

1. “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг зөрчиж хүчин төгөлдөр бус төлбөрийн хүсэлт, анхан шатны баримтыг дэмжих нотлох баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийдэг явдлыг зогсоож цаашид амлалтын бүртгэл, орлого бууруулсан гүйлгээг журмын дагуу хийж гүйцэтгэх

2. Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 -д заасны дагуу төсвийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж тайланг улирал тутамд гаргаж Сангийн яаманд хүргүүлж ажиллах

3. Төсвийн хөрөнгийг үр ашгийг дээшлүүлж техник хяналт, барьцаа дансанд зориулалт бус орлого байршуулдагыг зогсоож, техник хяналт болон барьцаа хөрөнгийн дансыг тус тусад нь данс нээж бүртгэж, магадалшгүй ажлын зардлын 39.8 төгрөгийг тухайн орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлж.

4. Төсөл арга хэмжээний шилжүүлгийн гүйлгээг батлахдаа гэрээ батлагдахаас өмнө санхүүжилт олгодог байдлыг зогсоож, ажлын гэрээнд заасан заалтыг бүрэн мөрдөж байгаа эсэх, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаад хяналт тавьж ажиллах

5. Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнг сумдад ажиллах нөхцөлөөр хангах, дотоод хяналтыг сумдын төрийн сангийн нэгжүүдийн 70-с багагүй хувьд үр дүнтэй зохион байгуулах.

6. Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 2.2.4-т сумын статистик мэдээллийн нэгтгэлийг төсөв, төрийн сангийн мэргэжилтэн хийхээр заасныг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ